МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр Дугаар А/561 Мөрөн сум

Мотоциклын хөдөлгөөнийг түр хугацаанд
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5, 28.1.10, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн саналыг харгалзан цаг агаар хүйтэрч, хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан хүний эрүүл мэнд, амь насанд учирч болох осол гэмтлээс үүдэлтэй эрсдэл, хохирлоос урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг түр хориглосугай.

2. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, санамж, сэрэмжлүүлэг өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011270